



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20~~20~~ оны 11 сарын 23 едер

Дугаар №655

Алтай хот

Г Аймгийн аюулгүйн нөөцөд өвс Т
бэлтгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээрзүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 178, 138 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны А/136 дугаар захирамжаар батлагдсан “Гамшгийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4 дэх хэсэг, аймгийн Онцгой комиссын 2020 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Засгийн газрын тогтоолоор тус аймагт олгогдсон хөрөнгийн үлдэгдэл 35.6 сая төгрөгөөр аймгийн аюулгүйн нөөцөд өвс худалдан авах ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Л.Насанбуян)-т олгосугай.

2. Засгийн газраас тус аймагт хуваарилсан хөрөнгийг аймгийн гамшигийн санд төвлөрүүлэх, өвс бэлтгэх хөрөнгийг тус сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Л.Насанбуян)-т үүрэг болгосугай.

4. Ажлын гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Мэргэжлийн хяналтын газар (Г.Гантулга)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

